



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 80

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай


Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 2.4, 8.г дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 нэр төрлийн 5.903.208 /таван сая есөн зуун гурван мянга хоёр зуун найман/ төгрөгийн анхны өртөгтэй, 3,173,240.26 /гурван сая нэг зуун далан гурван мянган хоёр зуун дөчин төгрөг хорин зургаан/ мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг хавсралтын дагуу акталж устгах, Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2006 онд бүртгэж авсан 894,200 /найман ерэн дөрвөн мянга хоёр зуун төгрөг/-ийн дуусаагүй барилгыг актлах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг тус тус зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасах, Эрүүл мэндийн төвийн дарга /Э.Одончимэг/-т, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд зохих хууль журмын дагуу бүртгэж авахыг Засаг даргын тамгын газрын дарга /Б.Энхтуяа/ нарт тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА С. СҮХБААТАР



0100139

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 2017 оны 08 сарын 14 өдрийн
 62 дугаар тогтоолын хавсралт



Актлаж, устгах хөрөнгийн жагсаалт

Үндсэн мэдээлэл			Ашиглалтын хугацаа		Элэгдэл				ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ	
№	Үндсэн нэр	Нэгжийн өртөг	Нийт өртөг	Ашиглалтын орсон огноо	Ашиглагдах жил	Оны эхний хуримтлагдсан элэгдэл	Тухайн сард нэмж байгуулсан элэгдэл	Нийт нэмж байгуулсан элэгдэл		Элэгдлийн дүн
1	Граш	747,054	1,494,108	1992.07.01	15	1,494,108	-	-	1,494,108	-
2	Халаалтын зуухны барилга	4,409,100	4,409,100	2006.12.30	60	1,660,761.01	18,371.25	1,679,132.26	1,679,132.26	1,679,132.26
3	Дуусаагүй барилга	894,200	894,200	2006		-	-	-	-	894,200
	ДҮН	5,156,154	5,903,208	-	-	3,134,869	18,371,25	1,679,132.26	3,173,240.26	1,679,132.26